



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/158

Чингис хот

Газар эзэмших эрхийн  
гэрчилгээг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу “Амарлан оршихуй” ХХК-ий /2875888/ эзэмшлийн Хэрлэн сумын 2 дугаар баг /Булаг/, Тэмүүжин гудамж Н-07 тоотод байршилтай үйлчилгээний зориулалттай 4080 м<sup>2</sup> газрыг иргэн Цэрэннадмидын Цэрэнпагамд 48 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.


2. Иргэн Ц.Цэрэнпагамын эзэмшил газрын тойм зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Ц.Цэрэнпагамд үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2009 оны 165 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ

• 231010436